



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/341

Улаанбаатар хот

Газар эзэмшүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 21.5.4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоол “Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт” болон нийслэлийн Засаг даргын 2025 оны А/715 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар дээрээ олон жил амьдарч байгаа иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хавсралтад дурдсан нэр бүхий 175 (нэг зуун далан тав) иргэнд газар эзэмшүүлэх эрх олгосугай.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Н.Насанбуян)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011005